

## **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх, зохицуулалтын оновчтой хэлбэрийг тогтоон нэвтрүүлэх, мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг дэмжин бататгах, мэргэшсэн боловсон хүчнийг төлөвшүүлэн хөгжүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос 2007 оныг “Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн жил” болгон зарлаж, энэ ажлын хүрээнд батлагдсан тусгай төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явдал Хорооны тайлант оны гол зорилт байлаа.


Түүнчлэн Хорооны бүтэц, зохион байгуулалт болон түүний үндсэн нэгжүүдийн чиг үүргийг оновчтой тогтоон, шаардлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, үйл ажиллагааныхаа бүхий л хэлбэрийг стандартжуулан хэвшүүлэх, Хорооны үйл ажиллагааг хэвийн жигд явуулах нөхцөлийг бүрдүүлж зүгшрүүлэх, шинэ тутам байгуулагдсан байгууллагаа олон нийтэд сурталчлан таниулах, гадаад, дотоод харилцааг өргөтгөхийн зэрэгцээ зохицуулалтын хүрээнд хамрагдах байгууллагуудын үйл ажиллагаанд Хорооноос тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тавих хяналтыг тогтмолжуулж, зайнаас хийх болон графикт шалгалтын үр нөлөөг сайжруулах зорилт тавин ажилласан болно.

Тайлант онд Хороо 18 удаа хуралдаж, цаг үеийн тулгамдсан 238 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 215 тогтоол, 18 тэмдэглэл гарган, хэрэгжилтийн явцад нь байнгын хяналт тавьж, биелэлтийг нь бүртгэл хяналтын картаар тооцож улирал бүр гарган ажилласнаас харахад хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн тоо 2006 оныхоос 2 дахин нэмэгджээ.

Гадаад, дотоодын байгууллага, хүмүүсээс нийт 4398 албан бичиг, факс хүлээн авч хариу илгээж, иргэдээс ирүүлсэн 866 өргөдөл, гомдлын 836-г нь хянан шалгаж, барагдуулсан байна.

Хороо АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Санхүүгийн салбарыг шинэчлэх, техникийн туслалцаа үзүүлэх төсөл”-ийн зөвлөхүүдээс гаргасан зөвлөмжийг харгалзан Ажлын албаныхаа бүтцэд гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудын жишгийн дагуу өөрчлөлт оруулж, дотоод бүтцийн нэгжүүдээ зохицуулалтын салбаруудын чиглэлээр зохион байгуулснаар Ажлын алба нь Үнэт цаасны газар, Даатгалын газар, Хадгаламж, зээлийн хоршоодын газар, Банк бус санхүүгийн байгууллагын газар, Тамгын газар, Эрх зүйн хэлтэс, Гадаад харилцааны хэлтэс гэсэн 7 нэгжтэйгээр ажиллах болсон.

Ажлын албаны гүйцэтгэлийн шуурхай ажиллагаа, Хорооноос гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, удирдлагад зөвлөх үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Дотоод хяналтын нэгжийг Алба болгон бэхжүүлж, үйл ажиллагааных нь хараат бус байдлыг хангах зорилгоор Хорооны даргын дэргэд ажиллуулах болсон. /Хорооны шинэчилсэн бүтцийг харуулав/.



СЗХ-ны Ерөнхий менежерээс Төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллан, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох газруудад хүргүүлж байлаа.

Хороо үйл ажиллагааныхаа дунд хугацааны хэтийн төлөвлөгөө буюу 2008-2010 онд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, мөрдөх болсон. Ажлын албаны дотоод бүтцийн нэгжүүд жил, сарын ажлын төлөвлөгөөгөө түүнтэй уялдуулан боловсруулж, биелэлтийг нь ханган ажиллах боллоо.

СЗХ-ны ажлын байрны хүрэлцээ туйлын хангалтгүй байсныг үндэслэн Засгийн газарт асуудлыг тавьсны үр дүнд Засгийн газрын IV байрын өргөтгөлийн барилгыг Хорооны өмчлөлд шилжүүлж өгсөн болно. 1960-аад онд хурлын заалны зориулалтаар баригдсан уг барилгын хананд суулт өгснөөс цууралт үүсч, ажлын байрны шугамаар ашиглаж болохгүй гэсэн мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт удаа дараа гарч байсныг харгалзан нурааж, оронд нь “Санхүүгийн боловсрол, сургалтын нэгдсэн төв”-ийн барилгыг барих тухай асуудлыг Засгийн газар, УИХ-д тавьсныг дэмжин, санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт суулган өгсөн юм.

Банкнаас бусад санхүүгийн зах зээлийг богино хугацаанд олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх, дэд бүтцийг нь бэхжүүлэх, зохицуулалтыг нь боловсронгуй болгох, өндөр мэргэшилтэй боловсон хүчнээр хангах зорилгоор Хороо гадаад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай харилцан мэдээлэл, туршлага солилцох чиглэлээр хамтын ажиллагаа өрнүүлэхийг чармайн ажиллахын зэрэгцээ үнэт цаас, даатгалын олон улсын

байгууллагуудаас зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд гишүүнийхээ хувьд төсөв, санхүүгийн бололцооныхоо хэрээр идэвхтэй оролцож байна.

Даатгалын хяналт шалгалтын олон улсын холбоо (IAIS) Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан гишүүнээр элсэх тухай хүсэлтийг нааштайгаар хүлээн авч дэмжин, 2007 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр албан ёсны гишүүн болгосон явдал нь Хороог олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, хамтын ажиллагааны эхлэлийг тавилаа.

Хороо санхүүгийн зах зээл дээр ажилладаг боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх талаар санаачлагатай ажиллан гадаадын 10 гаруй байгууллагатай хамтран төрөлжсөн сургалтууд зохион байгуулсан нь зохицуулах болон мэргэжлийн байгууллагуудын харилцан итгэлцлийг бий болгож, нийтлэг зорилгоо зөв тодорхойлж, байр сууриа нэгтгэн хөгжлийн төлөө хамтын хүчний давуу талыг ашиглан ажиллахад зохих түлхэц боллоо.

Олон улсын банк, санхүүгийн болон хөгжлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, Хорооны хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээний тулгамдсан асуудлуудыг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар шийдвэрлэх талаар онцгой анхаарал тавьж ажиллаж байна.

Үнэт цаасны хороодын Олон улсын байгууллагаас (IOSCO) тавьсан “2010 оны 1 дүгээр сарын 1-ний дотор бүх гишүүн байгууллагаас “Олон талт харилцан ойлголцлын санамж бичиг”-т нэгдүүлэх” зорилтын хүрээнд АХБ-ны санхүүжилтээр Азийн бүсэд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт Санхүүгийн зохицуулах хороог хамруулах тухай асуудлыг АХБ-д тавьж, уг санамж бичигт нэгдэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор олон улсын эксперт ажиллуулах 30000 ам.долларын буцалтгүй тусламжийг авахаар боллоо.

АХБ-ны санхүүжилттэй “Санхүүгийн салбарыг шинэчлэх, чадавхийг бэхжүүлэх - ТА №4737МОН төсөл”-ийн Санхүүгийн зохицуулах хороотой хамаарах бүрэлдэхүүн хэсгийг амжилттай хэрэгжүүлж, төгсгөлийн шатанд нь хүргэлээ.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD)-ны 300 мянган еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Даатгалын салбарын зохицуулалтыг сайжруулах” чиглэлээр техникийн туслалцаа авахаар тохирлоо.

JICA, KOICA, USAID зэрэг байгууллагууд, Япон, Турк улсын элчин сайдын яамдтай найрсаг харилцаа тогтоож, санхүүгийн зах зээлийн боловсон хүчнийг бэлтгэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, гадаад орнуудад зохиогдож буй сургалтуудад оролцох Хорооны төлөөлөгчдийн санхүүжилтийг хариуцах зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар тогтлоо.

Хороо Сангийн яам, Монголбанк, Барилга, хот байгуулалтын яам, МХАҮТ, “Хас” банк, ”Малын индексжүүлсэн даатгалын төсөл”-ийн хэрэгжүүлэгч нэгж зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж байна.

## **ХОЁР.САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нь иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд

оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий зорилтуудыг хэрхэн ханган хэрэгжүүлж байгаагаар тодорхойлогддог. Иймээс эдгээр зорилтуудыг бид дунд хугацааны бодлогын баримт бичигтээ тусган ажиллаа.

## **1.ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ:**

“Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн жил”-ийн ажлын хүрээнд энэ зах зээлийг хөгжүүлэх асуудалд төр засаг, олон нийтийн анхаарлыг хандуулах, компанийн засаглалыг сайжруулж, мэргэжлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, төрийн хяналт, зохицуулалтыг оновчтой болгох, хөрөнгө оруулагчдыг идэвхжүүлэх, иргэдэд хүргэх мэдээллийн үнэн бодит байдлыг дээшлүүлэх зэрэг асуудлуудыг гол зорилтоо гэж тодорхойлсон юм.

### **А.Иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах талаар**

Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал нь ямагт Хорооны анхаарлын төвд байдаг бөгөөд зах зээлд шинэ шинэ харилцаанууд эрчимтэйгээр нэвтэрч буй өнөө үед бүр ч онцгой байр суурийг эзлэх болж байна. Энэ чиглэлээр “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай”, “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай”, “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэх тухай”, “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх өвлүүлэх тухай”, “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” зэрэг журмуудыг шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Монгол Улсын эрдэс баялаг, ашигт малтмалын нөөц, түүний илэрц гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг зүй ёсоор татах боллоо. Стратегийн орд газрыг ашиглах хөрөнгийн 10-аас доошгүй хувийг хувьцаа гаргах замаар Хөрөнгийн биржээр дамжуулан арилжих болсон нь гадаадын үнэт цаасыг Монголын зах зээлд арилжих, Монголын үнэт цаасыг гадаадын зах зээлд арилжих боломжийг эрэлхийлэхэд хүргэж байна. Энэ бүгдийг цаг алдалгүй мэдэрч, холбогдох зохицуулалтын механизмыг бүрдүүлэх зорилгоор “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль болон холбогдох журмуудын төслийг боловсрууллаа.

Орон сууцны санхүүжилтийг сайжруулж, ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай хуулийн төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж Улсын Их Хуралд өргөн барилаа. Түүнчлэн Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан өрийн бичгийн тухай, Үнэт цаасжуулах болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиудын үзэл баримтлал, төслийг USAID-ийн санхүүжилтэйгээр уригдсан олон улсын зөвлөх, бусад байгууллагуудын оролцоотойгоор боловсруулаад ХЗДХЯ-нд шилжүүллээ. Мөн Эрүүгийн хуульд зарим төрлийн санхүүгийн гэмт хэргийг тодорхойлоогүй байсныг судалгаагаар тогтоон, “Нотариатч, эрхийн улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих”, “Хоршооны тухай хууль тогтоомж зөрчих”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчих”, “Даатгалын тухай хууль тогтоомж зөрчих” гэсэн 4 зүйл анги шинээр нэмэх саналыг холбогдох байгууллагуудад тавьсан нь дэмжигдсэн юм.

Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн үүргийн биелэлтийг хангуулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тэдгээрийг шаардлагатай мэдээллээр тухай бүр хангах зэрэг асуудлыг олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх замаар шийдвэрлэх шаардлага хурцаар тавигдаж байна. Ийм ч учраас эдгээр зарчмуудад тулгуурлан боловсруулсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг Хороо батлан гаргалаа. Энэ кодекс нь зөвхөн хувьцаат компаниудад хамаарах бус аливаа бизнесийн байгууллагын менежментэд нэвтрүүлж, компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлбэл зохих зөвлөмжийн чанартай баримт бичиг юм.

Зардал хөрөнгө, нарийн мэргэжил, мэргэшил шаардсан энэ зах зээлийн тулгамдсан асуудлуудыг төр засаг, олон улсын банк, санхүүгийн болон хандивлагч байгууллага, олон нийт, мэргэжлийн байгууллагуудын хамтын хүч хөдөлмөр, санхүүгийн дэмжлэгтэйгээр богино хугацаанд шийдвэрлэн хэрэгжүүлэх зорилгоор УИХ-д өргөн барьж батлуулах “Хөрөнгийн зах зээлийг 2008-2011 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж дуусгалаа.

Аливаа зах зээлийн хөгжлийн асуудал түүнд оролцогч мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын төлөвшилт, зохицуулалтын арга хэмжээнээс ангид байх учиргүй. Хороо Монголын хөрөнгийн зах зээлийн цорын ганц арилжаа эрхлэгч байгууллага болох Хөрөнгийн биржийн арилжааны болон бүртгэлийн журмуудыг шинэчлэн боловсруулах, “МХБ-ийн техник, технологийн шинэчлэлийн хөтөлбөр”-ийг боловсруулахад нухацтай хандан, тодорхой саналуудыг хүргүүлэн тусгуулсан юм.

Зургаан зуу шахуу мянган иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа 1 триллион орчим төгрөгийн үнэт цаас, мөнгөн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангаж байдаг Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн үйл ажиллагаанд “E-Clearing house” шинэ программ хангамжийг шинээр туршин нэвтрүүлээд байна.

Тайлант онд “МХБ” ХК, “ҮЦТТТХТ” ХХК, 15 БДК-ийн тусгай зөвшөөрлийг сунгаж, “Батс”, “Глобал ассет”, “Си Си Пи”, “Фронтнер”, “Блюмсбери секьюритис” зэрэг 9 компанид шинээр тусгай зөвшөөрөл олгосноор БДК-ийн тоо 36-д хүрсний 8 нь андеррайтерийн үйл ажиллагаа явуулах боллоо. Мөн 8 компанид нэмэлт зөвшөөрөл олгосноос 3 нь андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх, 2 нь хөрөнгө оруулалтын зөвлөхийн, 2 нь брокер-дилерийн үйл ажиллагаа эрхлэх нэмэлт зөвшөөрлийг тус тус авчээ. Нэмэлт зөвшөөрөл авсан 8 компанийн 5 нь Америк, Өмнөд солонгос, Япон зэрэг орнуудын хөрөнгө оруулалттай компаниуд байна.

Зах зээлд нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, дотоодын хөрөнгө оруулагч нарыг дэмжих замаар зах зээлийн идэвхийг сэргээн, хөгжлийг түргэсгэх бодлого барин ажиллалаа. Энэ ажлын хүрээнд “Туул-Сонгино усны нөөц”, “Хай би ойл”, “Оллоо”, “Нако түлш”, “Монфреш шүүс” “Монинжбар” зэрэг 6 компаниас нийтэд санал болгон гаргах үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтийг ирүүлснийг хянан шалгаад, 123.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 145.8 сая ширхэг хувьцаа, 2.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 100 мянган ширхэг бондыг бүртгэж, арилжаалах зөвшөөрөл олголоо.

### **Б.Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар**

Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх асуудал ялангуяа үнэт цаасны зах зээлд туйлын чухлаар тавигдаж байна. Учир нь 1990-ээд оны эхэнд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцааны эзэн болсон олон мянган иргэн эзэмшиж буй хөрөнгийнхөө мөн чанарыг мэдэхгүй буюу дутуу ойлгосноосоо болоод Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд харилцах дансаа ч нээлгээгүй, нээлгэсэн ч хяналт тавих арга механизмаа бүрэн мэдэхгүй байгааг яах аргагүй санхүүгийн дулимаг боловсролтой холбож үзэхээс өөр аргагүй юм.

Хороо төсвийн хөрөнгийнхөө боломжийн хэрээр үнэт цаасны зах зээлийн онцлог, цаашдын хандлага, арга хэрэгслүүдийн талаар ойлголт өгөх гарын авлага, материал хэвлэн иргэдэд тараах, тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулан санхүүжүүлэх зэрэг ажлуудыг хийлээ. Тухайлбал,

- “Хувьцаа эзэмшигчдийн өдөр”-ийг Хөрөнгийн биржтэй хамтран зохион байгуулж, хөрөнгийн зах зээлийн хөгжил, иргэдийн оролцоог сурталчлан таниулав.
- “Хөрөнгийн зах зээлийн хөгжил” сэдэвт эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаан зарлан, эрдэмтэн мэргэд, оюутан судлаачдыг өргөнөөр хамруулав. Уралдаанд оролцсон 36 оюутан, 22 судлаачийн бүтээлээр 3 боть эмхэтгэл хэвлүүлж, 5 оюутан, 4 судлаачийн бүтээлийг шалгаруулан урамшууллаа.
- “Хөрөнгийн зах зээлийн хөгжил-2007” сэдэвт нийтийг хамарсан өдөрлөгийг анх удаагаа Улаанбаатар хотод тусгай хөтөлбөрөөр, бүх аймгуудад удирдамжийн дагуу зохион байгуулж, нийт 7 мянга гаруй иргэдийг хамрууллаа. Зөвхөн Сүхбаатарын талбайд болсон өдөрлөгийн үеэр 589 хүнд зөвлөгөө өгч, танилцуулга, лавлагаа, зөвлөмжийн эмхэтгэлийг тараан сурталчилсан ба 394 иргэн ҮЦТТХТ-д данс нээлгэлээ.
- Үнэт цаасны хороонуудын олон улсын байгууллага /IOSCO/-гын зарчмууд, эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн олон улсын байгууллага /OECD/-гын компанийн засаглалын зарчмууд зэрэг олон улсын зөвлөмж, стандартыг монгол хэлнээ орчуулж, компанийн засаглалын зарчмуудыг хэвлэж, нийтийн хүртээл болгосны дээр үндэсний стандарт болгон батлууллаа.
- Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл, Хорооноос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн талаар радио, телевиз, сонин хэвлэлээр өргөн сурталчилж ажиллав.

Хороо болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын ажилтнуудын мэргэшил, чадавхийг дээшлүүлэх асуудал зах зээлийн хөгжлийн хэмнэлийг даган хурцаар тавигдаж байгаа бөгөөд энэ хэрэгцээг өнөөхөндөө төрөлжсөн сургалт-семинар зохион байгуулах, гадна дотны байгууллагуудаас зохиож буй сургалтуудад оролцуулах төдийхнээр хангаж байна.

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох сургалтыг 2 удаа явуулж, 176 хүнийг хамруулж, 132 хүнд эрх олгов. Хамтын ажиллагааны хүрээнд МУИС, ОХУ-ын Плехановын нэрэмжит Эдийн засгийн академи, Блюмберг, Ройтерс агентлаг, АХБ, Тайваны Хөрөнгийн бирж, Солонгосын Санхүүгийн хяналтын хороотой хамтран зохион байгуулсан сургалт, семинаруудад ажилтнуудаа идэвхтэй оролцууллаа.

**В.Санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар**

Өмч хувьчлалын “цэнхэр” тасалбараар иргэдийн өмчлөх эрхэд шилжсэн хувьцааг эзнийх нь зөвшөөрөлгүйгээр зарж үрэгдүүлэн, ашиглах гэмт үйлдэл үнэт цаасны зах зээл дээр 90-д оны дунд үеэс 2000-д оны эхэн үе хүртэл нилээд түгээмэл гарч байсан нь тухайн зах зээлийн зохицуулалт сул, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй, мэргэжлийн байгууллагуудад ажиллагсдын ёс зүй төлөвшөөгүй, иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсролын түвшин туйлын дорой байсан зэрэг олон хүчин зүйлээс улбаалан шалтгаалсан юм. Энэ хууль бус үйлдлийн үр дагавар өнөөг хүртэл арилаагүй, иргэдийг бухимдуулсан, төрийн үйлчилгээг хүндрүүлсэн хэвээр байна.

Тайлант онд хөрөнгийн зах зээл дээрх үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын зонхилох хувь нь чухам энэхүү асуудалтай холбоотой байсныг барагдуулах нөр их хөдөлмөр, судалгаа, нотолгоо шаардсан ажлыг өрнүүлсэн юм. Хорооны шийдвэрээр 24 иргэний 614.0 сая төгрөгийн зах зээлийн үнэ бүхий 3.9 сая ширхэг хувьцааг хууль зөрчин арилжсантай холбоотой 23 удаагийн хэлцлийг хүчингүй болгож, иргэдээ хохиролгүй болгов.

Хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүднээс 2 удаагийн захиргааны хэргийн шүүх хуралд оролцон, 90 сая төгрөгийн зах зээлийн үнэ бүхий 23.1 ширхэг хувьцааг зарж үрэгдүүлсэн 1 удаагийн үйлдлийн буруутай этгээдийг тогтоосон байцаагчийн дүгнэлтийг хамгаалсан болно.

Хувьцаат компани зохион байгуулалтын хэлбэрээ ХХК болгон өөрчлөх явцад жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөн хохирох явдал болзошгүй эрсдэлийн нэг байдаг. Энэ онд Хороо зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөхөөр хүсэлтээ ирүүлсэн 11 ХК-ийн хувьцаа эзэмшигч 3926 хүний 1.3 сая ширхэг хувьцааг бүртгэлээс хасч, 3838 хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох 29.2 сая төгрөгийг ҮЦТТХТ дахь дансадад нь байршуулав.

ХК-ийн хувьцааны хяналтын багцыг эзэмшиж буй этгээд бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах тендер санал гаргах үүрэгтэйг Компанийн тухай хуульд заасан нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалсан зохицуулалт болж байдаг. Хорооноос энэ зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хувьцааны хяналтын багц эзэмшигчдэд хууль ёсны шаардлага хүргүүлж, хяналт тавьж ажилласны үр дүнд 7 ХК-ийн хяналтын багцыг эзэмшигчид тендер санал зарлах хүсэлтээ ирүүлснийг хянан шийдвэрлэсэн юм. Одоогоор 4 тендер саналын хугацаа дууссан бөгөөд тэдгээр саналын хүчинтэй байх хугацаанд 7.4 мянган ширхэг хувьцаа худалдагдсан байна.

Дампуурсан буюу татан буугдсан банкуудад байршуулж байснаас эрсдэлд оруулсан харилцагчдын мөнгийг Засгийн газрын 2006 оны 155 дугаар тогтоолын дагуу олгох ажлыг ҮЦТТХТ-тай хамтран орон даяар зохион байгуулж, 57870 иргэнд 45.8 сая төгрөгийг олголоо.

### **Г. Санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах талаар**

“Компанийн тухай”, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулиудын хэрэгжилтийн байдлыг үнэт цаас нь Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагуудын хүрээнд шалгах үзлэгийг 2007 оны эхний хагас жилд багтаан дуусгав. Үзлэгт хөдөө орон нутгийн 251 ХК-ийн 202 нь,

нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 132 ХК-ийн 126 нь, нийт 309 ХК, 25 брокер, дилерийн компани хамрагдав.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 151 ХК, тогтмол бус үйл ажиллагаатай 62 ХК байгаа бол үйл ажиллагаагаа зогсоосон 146 ХК-ийн 67 нь хувь нийлүүлсэн хөрөнгөө үрэн таран хийснээс цаашид ажиллах ямар ч боломжгүй болсныг нь үзлэгийн дүн харууллаа. Энэ байдал нь Хөрөнгийн биржийн бүртгэлийг цэвэрлэн цэгцэлж, бүртгэлийн шаардлагыг олон улсын түвшинд нийцүүлэн өндөрсгөж, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангаж, үнэт цаасны зах зээлийнхээ тогтолцоог эрүүлжүүлэн, дэлхийн улс гүрнүүдийн нийтлэг чиг хандлагад хүргэх цаг хэдий нь болсныг нотолж байгаа юм.

Брокер, дилерийн компанийн /БДК/ шалгалтаар 4 компани “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг, 13 компани “Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын эргэлтийн хөрөнгийн доод хэмжээг тогтоох болон болзошгүй эрсдлээс харилцагчдыг хамгаалах сан байгуулах тухай түр журам”-д заасан эрсдлийн сан байгуулах шаардлагыг тус тус хангаагүй нь илэрсэн.

БДК-дын үйл ажиллагаанд гарч буй нийтлэг дутагдлуудаас дурдвал:

- компанийн дүрэмд орсон өөрчлөлтүүдийг Улсын бүртгэлийн албанд бүртгүүлдэггүй;
- компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдвөл зохих журмуудыг батлан мөрддөггүй;
- харилцагчдад шаардлагатай мэдээллийг өгдөггүй, тэдний зүгээс тавьсан санал хүсэлт, гаргасан өргөдөл гомдлыг шалган шийдвэрлэхэд хайнга, хойрго ханддаг;
- хувьцаа худалдсаны болон ногдол ашгийн мөнгийг хугацаанд нь олгожгүй харилцагчдыг чирэгдүүлдэг;
- жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтэлж, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдэд мэдээлэх, санхүүгийн тайлан, хувь нийлүүлэгчдийнхээ хурлын материалыг Хороонд ирүүлэх үүргээ биелүүлдэггүй байна.

Мөн иргэдийн хувьцааг зөвшөөрөлгүйгээр зарж үрэгдүүлсэн этгээдүүд татан буугдсан болон тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон БДК-дын харилцагчдын дансыг шилжүүлэн авсан БДК-ийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж, хариуцлагаас бултах явдал гарсаар байгаа нь тогтоогдлоо.

Орон нутагт үнэт цаасны мэргэжлийн үйлчилгээг хүргэх үүрэгтэй 16 БДК-иас Дорнод, Сүхбаатар, Төв, Булган, Орхон, Хэнтий, Баян-Өлгий, Увс аймгууд, Багануур дүүргийн ард иргэдэд үйлчилдэг БДК-иуд орон нутагтаа тогтсон хаяг байршилдаа байж, тодорхой хуваарийн дагуу тогтмол үйлчилгээ үзүүлдэг байхад Говьсүмбэр, Хөвсгөл аймагт БДК огт байхгүй, бусад аймгуудад байхгүйтэй адилхан байгаагаас хөдөөгийн иргэд маань дансныхаа үлдэгдлийг шалгах, үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгөх зэрэг наад захын хэрэгцээгээ хангахад бэрхшээлтэй тулгардаг байна.

Нөгөөтэйгүүр, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн гол байгууллага болох БДК-иуд санхүүгийн хувьд бүрэн бэхжиж чадаагүй, ашиг орлого муутай ажилладаг болох нь зөвхөн 2006 оны байдлаар нийт 25 БДК-ийн 14 нь 60 мянгаас 5.6 сая төгрөгийн алдагдалтай, 10 нь 42.3 мянгаас 47.2 сая төгрөгийн ашигтай ажилласнаас харагдаж байгаа юм.




Хувьцаат болон брокер, дилерийн компаниудын үйл ажиллагаанд хийсэн үзлэг, шалгалтын явцад илэрсэн зөрчлүүдийг арилгуулах арга хэмжээ авч, хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд 1.5 сая төгрөгийн захиргааны шийтгэл ногдуулав.

### Д.Зах зээлийн өнөөгийн байдал

Улс орны эдийн засгийн хурдацтай өсөлтийг дагаад хөрөнгийн зах зээл дээр нааштай эхлэлүүд ажиглагдаж, энэ салбарын үндсэн үзүүлэлтүүд огцом сайжирсан байна.

#### 1.Зах зээлийн мэргэжлийн оролцогчид



Үнэт цаас нь МХБ-д бүртгэлтэй ХК-ийн тоо буурах хандлагатай байгаа нь үнэт цаасны төвлөрөл үндсэн явагдаж дуусаад, хяналтын багцыг эзэмшигчид компанийнхаа хэлбэрийг өөрчилж ХХК болгох сонирхолтой байгаатай холбоотой юм. Нийт 2.5 тэрбум ширхэг хувьцаа бүртгүүлсэн 383 ХК-ийн дөнгөж 10 хүрэхгүй хувийнх нь үнэт цаас идэвхтэй арилжаалагддаг байна. Иймээс МХБ-ийн бүртгэлийг цэгцлэн цэвэрлэж, ХК-дын ангиллыг тогтоох шаардлагатай байна.

Үнэт цаасны арилжааны идэвх суларсан сүүлийн жилүүдэд БДК-дын тоо тогтвортой байсан бол энэ зах зээл дээр хөдөлгөөн орж, үндэсний компаниуд үнэт цаас гарган хөрөнгө оруулалтын эх үүсвэр татах явдал нэмэгдэж эхэлсэнтэй холбогдон шинээр 11 компанийн брокер, дилер, андеррайтерын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан болно.

2007 онд 119 ХК хувь нийлүүлэгчдийнхээ хурлыг хийж, 138 ХК санхүүгийн тайлангаа Хороонд ирүүлж, 28 ХК 7.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна.

#### 2.Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, ДНБ-д эзлэх хувь



Өмнөх оны эцэст 131.9 тэрбум төгрөгөөр үнэлэгдэж байсан үнэт цаасны зах зээлийн үнэлгээ тайлант онд 716.3 тэрбум төгрөгт хүрч, 585.7 тэрбум төгрөгөөр буюу 5.4 дахин өслөө.

Зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх сүүлийн 10 жилийн дундаж хувь 3.2 байсан бол тайлант онд 2006 оны үзүүлэлттэй харьцуулахад 11.6 хувиар огцом өссөнд идэвхтэй арилжигдаж буй хувьцаануудын үнэ өссөн, компаниуд шинээр үнэт цаас гаргаж эхэлсэн зэрэг нөлөөлсөн байна.


### 3. Үнэт цаасны арилжаа



2007 онд үнэт цаасны 253 удаагийн арилжаа явагдаж, 307 компанийн 116.1 сая ширхэг хувьцаа, 542.8 мянган ширхэг бонд арилжигдаж, нийт 102.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Нийт гүйлгээний үнийн дүнгийн 60.7% буюу 62.1 тэрбум төгрөгийг хувьцааны арилжааны, 39.3% буюу 40.5 тэрбум төгрөгийг бондын арилжааны үнийн дүн тус тус эзэлж байна.

Арилжааны хэмжээг өмнөх оны дүнтэй харьцуулахад хувьцааны арилжааны үнийн дүн 49.5 тэрбум төгрөгөөр буюу 4.9 дахин, бондын арилжааны үнийн дүн 35.0 тэрбум төгрөгөөр буюу 7.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.


### 4. Топ-20 үнийн индексийн динамик



1999 оны сүүл үеэс хэд хэдэн шалгуур үзүүлэлтээр сонгосон 20 үнэт цаасаар багц бүрдүүлэн “ТОП-20 индекс”-ийг тооцож үнэт цаасны зах зээлийн хөдөлгөөнийг харуулдаг болсон. Энэ индексийн өсөлт, бууралтаас зах зээлийн хөгжлийн ерөнхий хандлага өндөр мэдрэмжтэйгээр шалтгаалдаг тул тогтмол тооцон харж, зохицуулалтын арга хэмжээг уялдуулан авч хэрэгжүүлдэг юм.

ТОП-20 индекс 2006-12-31-нд 2030.8 нэгж байсан бол 2007-12-29-ний байдлаар 10256.1 нэгж өссөн ба тайлант хугацааны дээд үзүүлэлт 13676.9 нэгж байж өмнөх оныхоос 5.1 дахин өссөн үзүүлэлт гарлаа.

### 5.БДК-дын зах зээлд эзлэх хувь хэмжээ



Хөрөнгийн биржийн арилжаанд үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч болох БДК-дын хийсэн гүйлгээний дүнгээр тэдгээрийн энэ зах зээлд эзлэх буй хувь хэмжээг тогтооход нэр бүхий 5 компани нийт гүйлгээний 90 гаруй хувийг гүйцэтгэсэн байхад үлдсэн 31 БДК тус бүрт ойролцоогоор 0.3-хан хувь оногдож байгаа юм. Энэ байдал нь манай БДК-дын удирдлага, боловсон хүчний чадавхи сул, санхүүгийн чадамж хангалтгүй зэргээс улбаалан өрсөлдөх чадвар бүрдэж чадахгүй байгааг илтгэн харуулж буйн хэрэг юм. Тиймээс

БДК-дад тавих нөхцөл шаардлагуудыг өндөрсгөх замаар нэгдэн томорч, засаглал, менежментээ сайжруулах явдлыг дэмжин дэлгэрүүлэх хэрэгтэй юм.

### **Е.Цаашид авч хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээнүүд**

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эх орны эдийн засгийн хөгжлийн нэг гарц гэж үзэн онцгой ач холбогдол өгч, алдаатай тавигдсан суурийг нь засч залруулахын тулд өнгөрсөн 20-иод жилийн сургамж, олон улсын туршлагаас уйгагүй суралцан, өнөөгийн байдалд нь бодит дүгнэлт хийн, чиг хандлагыг нь зөв тодорхойлоод цаг алдалгүй шийдвэрлэвэл зохих олон тулгамдсан асуудлууд шил шилээ даран байгааг онцлон тэмдэглээд ирэх онд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг дурдвал:

-хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөрөнгө итгэмжлэн удирдах тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, заримыг нь эцэслэн боловсруулж шинээр батлуулах;

-хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төрийн нэгдсэн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх зорилгоор Хорооноос боловсруулаад байгаа “Хөрөнгийн зах зээлийг 2008-2011 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

-санхүү, эдийн засаг, нийгмийн асар өндөр эрсдэлийг агуулж байдаг нийтэд санал болгон шинээр үнэт цаас гаргах харилцааг үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдүүдийн үүрэг, хариуцлагатай уялдуулан зохицуулж, журамлах;

-хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн оролцогчдын ёс зүйн шаардлагыг өндөрсгөж, сахилга батыг чангатган хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх онцгой анхаарахын зэрэгцээ БДК-дыг санхүүгийн хувьд бэхжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах;

-орон нутагт үйлчилгээ үзүүлдэг БДК-ийн үйл ажиллагааг дэмжих, үйчилгээнийх нь стандартыг тогтоон хэрэгжүүлэх замаар зах зээлийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд хүргэж, тогтмолжуулах ажлыг зохион байгуулах;

-МХБ-ийг хувьчлах, ҮЦТТХТ-ийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлыг олон улсын жишигт нийцсэн, зах зээлийн хөгжилтөд эерэгээр нөлөөлөхүйц, оновчтой хэлбэрээр шийдвэрлэх;

-ХК-ийн үнэт цаасны бүртгэлд тавих шаардлагыг өндөрсгөж, чанар муутай үнэт цаасыг бүртгэлээс хасах замаар хөрөнгийн зах зээлийн бүртгэлийг сонгодог зах зээлийн түвшинд ойртуулж, хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс, бүртгэлтэй ХК-дын хувь нийлүүлсэн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

-хөрөнгө оруулагчдыг шаардлагатай, үнэн зөв мэдээллээр шуурхай хангаж, эрсдэлийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх, зах зээлийн оролцогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор шаардлагатай техник болон программ хангамжийн асуудлыг шийдвэрлэх замаар мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгон ажиллуулах;

-МХБ-ийн арилжаанд тавих хяналт, зохицуулалтыг нарийвчлан хэрэгжүүлэх замаар хувьцааны үнийг зохиомлоор өсгөж бууруулах, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, харилцагчийн хувьцааг зөвшөөрөлгүйгээр зарах зэрэг сөрөг үйлдлүүдийг таслан зогсоох механизм бүрдүүлэх;

-ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар эхлүүлсэн ажлаа үргэлжлүүлж, Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай, Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан өрийн бичгийн тухай, Үнэт цаасжуулах болон хөрөнгөөр

баталгаажсан үнэт цаасны тухай хуулиудын үзэл баримтлал, төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах;

-хөрөнгө оруулалтын сан, рейтингийн болон аналитикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах байгууллага, мэргэжилтнүүдийн санаачлага, энэ чиглэлээр гадаадын туршлага бүхий байгууллага Монголд хөрөнгө оруулах, салбар, төлөөлөгчийн газраа байгуулах явдлыг дэмжих;

-Хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн хувьцааны 75 хувийг эзэлдэг боловч сүүлийн хэдэн жил бараг эргэлтгүй, хөдөлгөөнгүй шахам байгаа төрийн эзэмшлийн хувьцааны менежментийг хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлд хандуулан сайжруулах талаар холбогдох байгууллагуудтай санал солилцож, зохих арга хэмжээ авч эхлэх зэрэг болно.

## **2.ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ:**

Даатгалын салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Даатгалын тухай”, “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай” хуулиудад заасан даатгалын багц дүрмийн жагсаалтад багтсан дүрэм, журам, заавруудыг боловсруулж дуусгах, даатгалын салбар дахь төрийн хяналт шалгалт, зохицуулалтыг оновчтой болгон төгөлдөржүүлэх, заавал болон урт хугацааны даатгалын тогтолцоог бүрэлдүүлэх бэлтгэл ажлыг хангах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах арга механизмуудыг судлан нэвтрүүлэх явдал 2007 оны зорилт байлаа.

### **А.Иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах талаар**

Даатгалын зах зээлийн эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн гэдэг хэдий ч Даатгалын тухай хууль болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн хүрээнд батлан мөрдүүлэх ёстой дүрэм, журам, зааврууд бүрэн боловсруулагдаагүй байсан юм. Хороо энэ онд “Даатгагчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, хэлбэрийн заавар”, “Даатгалын холбогдох этгээдийг тодорхойлох заавар”, “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих тухай журам”, “Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам” зэрэг 22 журам, заавар, аргачлалыг батлан мөрдүүлснээр энэ зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаа болон санхүүгийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх аргачлалыг тогтоон, урт хугацааны даатгалын эрх зүйн үндсийг тавьж, давхар даатгалын хяналтын механизмыг боловсронгуй болголоо. Түүнчлэн “Урт хугацааны сайн дурын даатгалын хэлбэрийн жагсаалт”, ”Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ыг баталж гаргаснаар амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалтын эхлэлийг тавилаа.

Даатгалын салбарт шинэ шинэ хэлбэрүүд нэвтрэн хэрэгжиж, зах зээлийн хамралтыг хүрээг эрс нэмэгдүүлэх урьдач нөхцөл нэгэнт тогтсоныг харгалзан эрх зүйн зохицуулалтыг нь хугацаа алдалгүй, шуурхай бүрдүүлэх үүднээс “Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын заавал даатгах даатгалын тухай” хуулийн төслийг боловсруулж, “Хадгаламжийн даатгалын тухай” хуулийн төслийг боловсруулахад идэвх, санаачлагатайгаар оролцлоо.

Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан орон сууцны зээлийн даатгалын эрх зүйн асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран судалгаа хийлээ.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 4-ийн “Даатгалын гэрээ” бүлгийг орчуулж, Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлөөр батлуулсан нь олон улсын хэмжээнд мөрдөгддөг стандартуудыг Монгол Улсын практикт нэвтрүүлэх ажлын эхлэл болсон юм.

Салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, мэргэжлийн оролцогчдыг эрх бүхий, мэргэшсэн боловсон хүчнээр хангах, даатгалын байгууллагад аудит хийх аудиторчдыг бэлтгэх зэрэг ажлууд тулгамдсан асуудал байсныг тодорхой хэмжээгээр шийдэж чадлаа. Энэ онд даатгалын 15 компанид давхардсан тоогоор 220 хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, Даатгалын тухай хуулийн шаардлага хангаагүй, нөөцийн санг зохих ёсоор бүрдүүлээгүй “Капитал даатгал”, “Чин үйлс даатгал”, “Монголын үндэсний даатгал”, “Эрэл даатгал” зэрэг компаниудын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.

“Ганзам даатгал”, “Ард даатгал” компаниудын үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх арга хэмжээ авч, илэрсэн зөрчил, дутагдлыг нь арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь хангуулан ажиллаж, тусгай зөвшөөрлийг нь сэргээсэн.

Улсын хэмжээнд даатгалын зуучлагч, төлөөлөгч зэрэг мэргэжлийн оролцогчдын хүрэлцээ дутмаг байгаа нь энэ салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсанд дүгнэлт хийн шийдвэрлэхэд анхаарч ажиллалаа. Тайлант онд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч ирүүлсэн 4 компанийн өргөдөл, материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шалгаж, шаардлага хангасан гэж үзсэн 2 байгууллагад энэ төрлийн зөвшөөрлийг олгосон. Даатгалын төлөөлөгчдийг бэлтгэн, эрх олгох сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн 286 хүнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

Даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх эрхийг Хорооноос олгохоор Даатгалын тухай хуульд зааж өгсөн явдал бол даатгуулагчдын эрх ашгийг хамгаалсан чухал зохицуулалт юм. 2007 онд 18 аудиторт энэ төрлийн эрх олгогдлоо.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD)-ны техник туслалцааны шугамаар хэрэгжих Даатгалын салбарын зохицуулалтыг сайжруулах төслийн олон улсын тендерийг зарлан явуулж дүгнэлээ.

Зах зээлийн зохицуулалтын хувьд даатгалын орлогын хураамжийн орлогыг тайлант үед жигд тогтвортой хуваарилан тооцдог “8-тын систем”-ийг нэвтрүүлж, ингэснээр, нэг талаар даатгалын компанийн санхүүгийн байдал, үр ашгийн түвшинг бодитойгоор тооцох боломжийг бүрдүүлж, нөгөө талаар даатгалын систем дэх орлогын бүртгэл, орлогод тооцох хураамжийн бүртгэл, нөөцийн сангийн тооцоололтыг олон улсын жишгийн дагуу хийх үндсэн аргачлалыг боловсруулан мөрдүүлэх боллоо.

### **Б.Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар**

Даатгалын салбарын онцлог, мөн чанар, даатгалд хамрагдахын ач холбогдлыг олон нийтэд тууштай ойлгуулж чадахгүй бол иргэд маань санхүү, эд хөрөнгө, сэтгэл санааны хохиролд өртөх эрсдэлийг үйл хөдлөл бүрийнхээ тоогоор амьдралынхаа туршид тээн явахад

хүрэх бөгөөд нөгөө талаар энэ зах зээлийн хөгжилд ч сөргөөр нөлөөлөх болно. Ийм учраас энэ салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийн үнэн бодит байдлыг бүрэн хангасан, ил тод, түргэн шуурхай ажиллагаатай, олон нийтэд хандсан, мэдээлэл хүргэх буюу зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх чадвар бүхий механизмыг бүрдүүлэх явдал чухлаар тавигдаж байгааг шийдвэрлэх зорилготой эхний алхмуудыг хийлээ.

Юуны түрүүнд, АХБ-наас Хороотой хамтран хэрэгжүүлж байгаа Санхүүгийн салбарыг шинэчлэх чадавхийг бэхжүүлэх ТА №4737МОН төслийн нэгжтэй хамтарч даатгалын салбарын мэдээллийг боловсруулах программын техникийн даалгаврыг боловсрууллаа. Ингэснээр даатгалын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах ажлын суурь тавигдсан юм.

Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор даатгалын зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар Хорооноос хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээнүүд, баталж мөрдүүлэхээр болсон журам, зааврууд, түүнчлэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн тайланд аудит хийх эрх авсан аудиторчуудын талаарх мэдээллийг Хорооны вэб-хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж, шаардлагатай тохиолдолд албан бичгээр лавлагаа гарган өгч ажиллалаа.

Иргэд, даатгуулагчдын даатгалын талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Даатгуулагчдын анхааралд” гэсэн нийтлэл бэлтгэн гаргаж, даатгалын зах зээлийн тулгамдсан асуудлуудаар 2 удаа телевизийн шууд нэвтрүүлэг зохион байгууллаа.

Санхүүгийн зах зээлийн хөгжилд тухайн салбарт ажиллаж буй зохицуулах болон мэргэжлийн байгууллагуудын боловсон хүчний мэргэшил, чадавхийг дээшлүүлэх асуудал нэн чухал байр суурийг эзэлж байгааг харгалзан даатгалын чиглэлээр төрөлжсөн сургалт, семинаруудыг зохион байгуулсныг дурдвал:

- даатгалын төлөөлөгч нарт зориулсан 2 удаагийн сургалт;
- даатгалын байгууллагын санхүү, бүртгэлийн ажилтнуудад зориулсан 2 удаагийн сургалт;
- урт хугацааны амьдралын даатгалын зохицуулалт болон актуарын чиглэлээр БНСУ-ын Санхүүгийн зохицуулалтын үйлчилгээний газар (FSS)-тай хамтарч зохиосон сургалт;
- урт хугацааны амьдралын даатгалын зохицуулалт, хяналт шалгалтын чиглэлээр БНЭУ-ын Даатгалын зохицуулалт, хөгжлийн газар (IRDA) болон “Нэйшнл лайф” ХХК-тай хамтарч зохиосон сургалт;
- малын индексжүүлсэн даатгалд малчдыг хамруулах асуудлаар хөдөө орон нутагт ажиллах даатгалын төлөөлөгчдийг сургаж бэлтгэх чиглэлээр “Малын индексжүүлсэн даатгалын төсөл”-ийн нэгжтэй хамтарч 3 аймагт зохиосон тусгай зөвшөөрөл олгох сургалтууд;
- даатгалын актуарын мэдлэг олгох чиглэлээр Люксембургийн Засгийн газрын санхүүжилтэйгээр Монголын даатгагчдын холбоотой хамтарч зохиосон сертификат олгох сургалт зэрэг болно.

### **В.Санхүүгийн зах зээлд оролцогчдын хүүль ёсны эрх ашгийг хамгаалах талаар**

Санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах явдал бол Санхүүгийн зохицуулах хорооны нэг гол чиг үүрэг юм гэдгийг даатгуулагч нар маань ойлгох болж эрх нь зөрчигдсөн тохиолдол бүрт Хороонд ханддаг болох хандлага ажиглагдаж эхэлж байна. Тайлант онд даатгуулагчдаас Хороонд хандаж ирүүлсэн 28 өргөдөл, гомдлын үндэслэлийг хянан шалгаж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгсөний зэрэгцээ даатгалтай холбоотой асуудлаар иргэд, харилцагчдаас ирүүлсэн 247 албан бичиг, хүсэлтийг судлан хянаж, хуулийн хугацаанд хариуг нь хүргүүллээ.

Зорчин явагч, тээвэрлэгчийн хариуцлагын даатгал нь сайн дурын даатгалын хэлбэрт хамаарагддаг хэдий ч тээврийн үйлчилгээ хариуцсан байгууллага, зарим даатгалын компани зорчигчийн билетийн үнэд шингээх замаар заавал даатгалын хэлбэрээр хураамж авдаг нь даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчин, иргэдийн бухимдлыг төрүүлж байсныг шалган тогтоож, холбогдох байгууллагуудтай хариуцлага тооцон, таслан зогсоох арга хэмжээ авсан.

Иргэд, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу даатгалын салбарын эрх зүйн болон зах зээлийн зохицуулалттай холбоотой зөвлөгөө өгөх үйлчилгээг тухай бүр үзүүлж байсан болно.

### **Г. Санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах талаар**

Даатгалын компаниудын тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгох ажлын хүрээнд тэдгээрийн үйл ажиллагаа, хууль тогтоомж, Хорооноос бүрэн эрхийнхээ хүрээнд батлан мөрдүүлж байгаа даатгалын багц дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж байгаа байдалд тусгай хуваарийн дагуу шалгалт хийж дуусгалаа.

Шалгалтын явцад манай компаниуд дараах зөрчил, дутагдлуудыг нийтлэг гаргадаг нь ажиглагдсаныг дурдвал:

- тусгай зөвшөөрөлгүй этгээдэд даатгалын төлөөлөгчийн шимтгэл төлдөг;
- нөөцийн санг буруу байгуулсан, уг сангийн хөрөнгийг Хорооноос тогтоосон хэмжээг зөрчин өөр төрлийн хөрөнгө оруулалтад байршуулсан;
- компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг хуульд заасны дагуу Улсын бүртгэлийн албанд бүртгүүлдэггүй;
- зарим сайн дурын даатгалыг тухайн чиглэлийн зохицуулалтын байгууллагаар дамжуулан албан хүчээр заавал даатгаж, Даатгалын тухай хуулийг зөрчдөг;
- даатгалын гэрээний үг хэллэг, томъёолол бүрхэг, хоёрдмол утгатай байдгаас үүдэн нөхөн төлбөр олгох явцад хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлэн залхаадаг байна.

Шалгалтаар илэрсэн буруутай үйл ажиллагаа, зөрчил, дутагдалтай холбогдуулан нийт 20 гаруй сая төгрөгийн торгуулийг даатгалын компаниудад хүлээлгэж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлснээс гадна засч залруулах, зогсоон арилгах үүрэг, даалгаврыг Улсын байцаагчийн албан шаардлагаар өгч, хэрэгжилтийн байдалд нь хяналт тавьж ажиллалаа. Хороо даатгалын салбарт гарч буй зөрчил, дутагдал гаргасан компани тус бүр дээр “зөрчлийн түүх” нээн бүртгэл хөтөлж эхэлсэн нь хяналтын нэг чухал хэрэгслийг нэвтрүүлэх арга хэмжээ болж байгаа юм.



Санхүүгийн байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийн зайны хяналтыг хэрэгжүүлэх нь нэг талаар бодлого тодорхойлох үндэслэл, нөгөө талаар эрсдэлийн удирдлагын хэрэгсэл, цаашилбал статистик мэдээллийн эх үүсвэр болдог.


Тайлант онд даатгалын зах зээлд оролцогч 15 компанийн санхүүгийн тайланг улирал бүр хүлээн авч, нэгтгэн шинжилж, зайнаас тавих хяналтыг хэрэгжүүллээ. Хорооноос дотоодын даатгалын зах зээлийг санхүүгийн эрсдэлээс хамгаалж тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий даатгагч нар 2007 онд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг үндсэнд нь бүрэн хангаж ажилласан байна.

Даатгалын компаниудын хөрөнгө санхүүгийн зохистой харьцааны гол үзүүлэлт болсон даатгалын нөөцийн сангийн хэмжээг нэмэгдүүлж баталгаажуулах зорилгоор “Даатгалын нөөцийн санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ыг мөрдүүлж ажилласны дүнд даатгалын салбарын нөөцийн сангийн хэмжээ өсч 17.8 тэрбум төгрөгт хүрснээр даатгагчдын төлбөрийн чадвар дээшилсэн болно.

#### Д.Зах зээлийн өнөөгийн байдал

Тайлант онд даатгалын системийн хэмжээгээр 633.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нөөцийн сангийнхаа хэмжээг 45.9 хувиар буюу 5.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 17.8 тэрбум төгрөгт хүргэж, 4.5 тэрбум төгрөгийн давхар даатгал хийсэн байна.

### 1.Нийт хөрөнгө



Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 28.4 тэрбум төгрөгт хүрч, 2006 оныхоос 36.5 хувиар буюу 7.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт хөрөнгийн 80 орчим хувийг бүрдүүлж байгаа эргэлтийн хөрөнгийн бүтцэд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 67.6 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 12.0 хувь, дансны авлага 9.4 хувь, бусад эргэлтийн хөрөнгө 11.0 хувь орчим байгаагаас харахад, түүнд мэдрэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.

Тайлант хугацаанд системийн хэмжээгээр 303.4 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажиллаж өмнөх оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 594.2 сая төгрөгөөр буюу 2.9 дахин буурсан үзүүлэлт гарчээ. Энэ нь 2007 оны сүүлийн хагас жилээс эхлэн нөөц сан байгуулах 8-тын систем нэвтрүүлсний эерэг үр дүн гарч байгааг харуулж байна.

## 2.Хураамжийн орлого



Даатгалын хураамжийн орлого сүүлийн жилүүдэд дунджаар 1.9 орчим тэрбум төгрөгөөр тогтвортой өсч байсан бол 2007 онд өмнөх оныхтой харьцуулахад 43.2 хувиар буюу 5.1 тэрбум төгрөгөөр огцом өссөн нь нэг талаас, даатгалын компаниуд шинэ бүтээгдэхүүнүүд бий болгон зах зээлд нэвтрүүлж байгаа, нөгөө талаас иргэд маань ч даатгалын ач холбогдлыг илүүтэйгээр ойлгох болж, учирч болох эрсдэлээс хамгаалахын тулд илүүтэйгээр даатгалд хамрагдах болж байгаатай холбоотойг энэхүү өсөлтийн 84.8 хувийг зөвхөн эд хөрөнгийн болон хариуцлагын даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн явдал тод харуулж байгаа юм.

Хураамжийн орлогыг даатгалын ангиллаар нь урьд оны үзүүлэлттэй харьцуулан хүснэгтлэн харуулбал дараах байдалтай байна.:


Даатгалын дэд ангилал	2006	2007	Өсөлт	
			сая төг.	хувь
1. Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	1 048.4	1 495.0	446.6	42.6
2. Эд хөрөнгийн даатгал	8 051.4	10 534.7	2 483.3	30.8
3. Хариуцлагын даатгал	2 679.3	4 566.4	1 887.1	70.4
4. Санхүүгийн даатгал		333.0	333.0	
<b>Дүн</b>	<b>11 779.1</b>	<b>16 929.1</b>	<b>5 150.0</b>	<b>143.7</b>

### 3.Хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь




Даатгалын хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь сүүлийн жилүүдэд буурах хандлагатай болж байгаад 2007 онд 0.05 пунктээр буюу 5.2 тэрбум төгрөгөөр өслөө. Дэлхийн хөгжингүй орнуудын хувьд 10 орчим хувь байдаг энэ үзүүлэлт Монголд 0.4 орчим хувьтай байгаа нь манай даатгалын зах зээлийн хамралт цаашид тэлж хөгжих өргөн боломжтойг, иргэд, олон нийтийн даатгалын талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар дорвитой ажил хийх ёстойг, энэ салбарт амьдралын болон төрөл бүрийн хариуцлагын заавал даатгалын хэлбэрүүдийг нэвтрүүлэх шаардлагатайг илтгэн харуулж байна.

### 4.Нөхөн төлбөр



Тайлант онд даатгалын компаниуд даатгуулагчдад 3.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь 2006 оныхтой харьцуулахад 21.6 хувиар өссөнд эд хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр 37.3 хувиар, хариуцлагын даатгалын нөхөн төлбөр 35.3 хувиар тус тус өссөн явдал голлон нөлөөлжээ.


## 5.Хохирол нөхөлтийн түвшин



Даатгалын салбарын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн сүүлийн 7 жилийн өөрчлөлтийн динамик хандлагаас харахад, даатгалын хураамжийн жилийн өсөлтийн хурдац нь нөхөн төлбөрийнхөөс бараг 5 дахин өндөр байгаа бөгөөд энэ үзүүлэлтүүдийн хоорондын зөрүү, ялангуяа, сүүлийн хоёр жилд эрс ихсэх хандлагатай болсон нь иргэд, даатгуулагчдын итгэлийг бууруулж, даатгалын зах зээлийн хөгжилтөд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүдийн нэг болох хохирол нөхөлтийн түвшинг Монголд нийт нөхөн төлбөрийг нийт хураамжийн орлогод харьцуулан тооцож хэвшсэн байсан бөгөөд энэ үзүүлэлт тайлант онд 19.9 хувьтай байлаа. Гэтэл олон улсын практикт хохирол нөхөлтийн түвшинг нийт нөхөн төлбөрийг даатгалын орлогод тооцсон хураамжид харьцуулан /loss ratio - 100 төгрөгийн хураамж тутмын хэдэн төгрөгийг даатгуулагчдад нөхөн төлбөр болгон буцаан олгож байгааг харуулдаг/ тооцдог нь манай тооцоололтой зөрж байсныг залруулж, 2007 оноос эхлэн мөрдөх болсон ба энэ үзүүлэлт 48.57 хувьтай гарсан нь хөгжингүй орнуудын ойролцоогоор 50 хувьтай байдаг дундаж үзүүлэлтэд илүү дөхүү байгааг илтгэж байгаа болно.

## 6.Даатгалын байгууллагуудын зах зээлд эзлэх хувь хэмжээ



Даатгалын байгууллагуудын зах зээлд эзлэх хувь хэмжээг тэдгээрийн хураамжийн орлогын дүнгээр тооцож үзвэл, нэр бүхий 5 компани нийт зах зээлийн 81.9 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, үлдэж буй 10 компанид дунджаар дөнгөж 1.8 хувь тус тус оногдож байна гэсэн үг юм. Энэ нь зах зээл дээр өрсөлдөөнт байдал үгүйлэгдэж, төлбөрийн өндөр чадвар, оновчтой менежмент бүхий компаниуд дутагдаж байгааг илтгэж буй хэрэг билээ.

### **Е.Цаашид авч хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээнүүд**

Даатгалын салбарын өмнө тулгарч буй дараах асуудлуудад онцлох ач холбогдол өгөн ойрын ирээдүйд шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ нь:

-даатгалын салбарын хөгжлийн түвшин эхлэлийн шатандаа байгааг харгалзан энэ зах зээл дээр нотариатч, өмгөөлөгч, шүүгч, эмч, хүнсний зүйл үйлдвэрлэгчид, орчин тойрноо хордуулж болзошгүй бодистой ажиллагчдын гэх мэт хариуцлагын заавал даатгал, амьдралын буюу урт хугацааны даатгал зэрэг шинэ шинэ бүтээгдэхүүнийг бий болгон нэвтрүүлж, тэдгээрийг зохицуулах дүрэм, журам, аргачлалыг боловсруулан мөрдүүлэх;

-Монгол орны даатгалын жижиг зах зээлийн өрсөлдөөнийг компанийн тоогоор бус удирдлага, засаглалын дэвшилтэт арга хэлбэрүүдийг нэвтрүүлснээр, санхүүгийн чадавхиар нь төсөөлж, дүрмийн болон нөөц сангийн хэмжээг өсгөх замаар нэгтгэн томруулах, эдгээр сангуудын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг санхүүгийн бусад зах зээлд хөрөнгө оруулалт хийн өсгөх боломжийг бүрдүүлэх бодлого барин Даатгалын тухай хуульд зохих өөрчлөлтүүдийг хийн хэрэгжүүлэх;

-гадны хөрөнгө оруулалттай даатгалын компани шинээр байгуулах, одоо ажиллаж байгаа компанийг худалдаж авах гэсэн сонирхол нэмэгдэж байгааг харгалзан дэлхийн болон бүс нутгийн туршлагыг судлан хэрэгжүүлэх, холбогдох дүрэм, журмыг боловсруулан мөрдүүлэх замаар дотоодын даатгалын зах зээлээ хамгаалах арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авах;

-Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аливаа байгууллагыг дотоодын даатгалын байгууллагад даатгуулдаг болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгож, гадаадын даатгалын компаниуд даатгалын төлөөлөгч,

зуучлагчдаар дамжуулан манай газар нутаг дээр зөвшөөрөлгүй даатгалын үйл ажиллагаа явуулах явдлыг зогсоох;

-давхар даатгалын хэлбэрээр их хэмжээний мөнгөн хөрөнгө гадаадын даатгалын компаниуд руу урсан гарч байгаад дүгнэлт хийн давхар даатгалын үндэсний компани үүсгэн байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх саналыг боловсруулж шийдвэрлүүлэх;

-даатгалын салбарын талаарх мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангах зорилгоор өнөөгийн шаардлагад нийцсэн программ хангамж бүхий мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, санхүүгийн тайлагналтын олон улсын стандартыг системийн хэмжээнд нэвтрүүлэн мөрдүүлэх зэрэг болно.

### **3.БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД**

Банк бус санхүүгийн байгууллагуудын /ББСБ/ бүртгэлийг шинэчлэн цэгцэлж, мэдээллийн сан бий болгох, энэ зах зээлийн багтаамжийг тодотгон тодорхойлж, Хорооноос баримтлах бодлогыг оновчтой томъёолон тогтоох, эрсдэлийн удирдлагыг хяналт, шалгалт, зохицуулалтын ажилд ашигладаг болох механизмыг бүрдүүлэх зорилттойгоор ажилласан.

#### **А.Иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг баталгах талаар**

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хууль эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор ББСБ-дын холбоо, тус салбарт ажиллаж буй мэргэжлийн байгууллагуудаас тавьж буй санал, хүсэлтийг шийдвэрлэх арга зам, гадаад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн байгууллагуудын жишиг, туршлагыг судалж “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах ажлыг эхлүүлээ.

ББСБ-дын үйл ажиллагаанд хийх зайнаас тавих хяналт, зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах, санхүүгийн чадавхийг нь дээшлүүлэх зорилгоор “ББСБ-дын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих аргачлал”, “Валют солих цэгийн үйл ажиллагааны зохицуулалтын түр журам”, “ББСБ-дын хувийн хэрэг хөтлөх заавар”, “ББСБ-дын нягтлан бодох бүртгэл хөтлөх үлгэрчилсэн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт” зэрэг 6 заавар, аргачлалыг батлан мөрдүүлээ.

Тайлант онд Монголбанкнаас банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 109 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгож, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 10 ХХК, дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшөөрөл хүссэн 17 ББСБ, салбар байгуулан ажиллахыг хүссэн 7 ББСБ-ын хүсэлтийг хянан шийдвэрлэж, 9 ББСБ-ын оноосон нэрийг өөрчиллөө.

ББСБ-ын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл хүндрэлүүд, хөгжлийн хандлага, зохицуулах байгууллагаас баримталж байгаа бодлого, шийдвэрүүдтэй холбоотой санал дүгнэлтүүдийг сонсож нэгтгэн дүгнээд, цаашид авах арга хэмжээнүүдийг боловсруулан төлөвлөх үүднээс Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг 86 ББСБ-ын удирдах ажилтнуудтай нэг бүрчлэн уулзаж, санал сэтгэгдлээ солилцов.

ББСБ-дын эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх бодлогын хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Тогтвортой амьжиргаа”

төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Бичил санхүүгийн хөгжлийн сангаар дамжуулан олгодог бөөний зээлд зохих шаардлагыг хангасан 7 ББСБ-ыг хамруулсан болно.

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Санхүүгийн салбарыг шинэчлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн нэгжтэй хамтарч ББСБ-ын холбогдолтой мэдээллийг боловсруулах программын техникийн даалгаврыг боловсруулсныг энэ салбарт мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах ажлын эхлэл гэж үзэж байгаа.

### **Б.Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар**

Банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор энэ зах зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд Хорооноос авч байгаа бодлогын арга хэмжээнүүд, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, зааврууд болон тусгай зөвшөөрөл авсан буюу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон байгууллагын талаар Хорооны вэб-хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж, шаардлагатай тохиолдолд албан тоотоор хүргүүлж ажиллалаа.

Санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх явдал бол салбарын хөгжил, тухайн байгууллагын хэвийн, эрсдэлгүй ажиллагааг хангахад нөлөөлөх чухал хүчин зүйл билээ. Энэ чиглэлээр 2007 оны 5 дугаар сард 67 ББСБ-ын удирдлага, нягтлан бодогчдыг хамруулсан сургалт-семинар зохион байгуулж, санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээ, зах зээлийн эрсдэл, ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, мөнгө угаахтай тэмцэх асуудлаар гадаад орнуудын хуримтлуулсан туршлага сэдвүүдээр хичээл заан, хяналт шалгалтын явцад илэрсэн нийтлэг зөрчил, дутагдлуудын талаар илэн далангүй ярилцсан болно.

### **В.Санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар**

Харилцагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, санхүүгийн үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж чадаж байгаа эсэхээс иргэдийн итгэл батжиж, зах зээлийн хүрээ тэлэн өргөжих зүй тогтолтой. ББСБ-ууд гол төлөв өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр зээлийн үйлчилгээ эрхэлж, болзошгүй эрсдэлийг өөрөө хариуцаж байдаг хэдий ч итгэлцэл, факторинг, мөнгөн гуйвуулгын зэрэг үйлчилгээг үзүүлэх явцад харилцагчид хохирох явдал гарахыг үгүйсгэх газаргүй юм. Иймд санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг бүрдүүлэн, харилцагчдыг шаардлагатай мэдээллээр тогтмол хангах нь эрх ашиг зөрчигдөх үйлдлээс урьдчилан сэргийлэх ажлын нэг хэлбэр болдог.

Энэ чиглэлээр Хорооноос тавьж буй шаардлагын дагуу ББСБ-ууд үйл ажиллагаатайгаа холбогдсон мэдээлэл байршуулах сурталчилгааны самбар ажиллуулж, танилцуулга, санхүүгийн хураангуй тайланг хэвлэн нийтэлж хэвшиж байгаа бөгөөд зарим байгууллагууд өөрийн гэсэн вэб-хуудас нээн ажиллуулж эхлээд байна.

Тайланд онд ББСБ-дын ажил, үйлстэй холбоотойгоор 450 гаруй албан бичиг өргөдөл, гомдол Хороонд ирснийг хянан шалгаж, хуулийн хугацаанд хариуг өглөө.

Зах зээлийн төрийн зохицуулалтыг хариуцсан байгууллагын хувьд Хороо нь зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудынхаа эрх ашгийг орхигдуулах учиргүй тул тэдгээрийн үйл ажиллагаанд саад бэрхшээл учруулж байгаа хууль тогтоомжийн заалт, томъёолол, тооцооллуудыг судлан шинжилж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхийг зорьж ажиллаж байна.

### **Г. Санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах талаар**

Хорооны хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 46 ББСБ-д тусгай удирдамжийн дагуу шалгалт хийхэд “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”, “Банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн журам” болон холбогдох бусад эрх зүйн актыг зөрчсөн үйлдлүүд илэрч байсны дотор:

- Хорооны зөвшөөрөлгүйгээр банк бус санхүүгийн зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, хуульд заагаагүй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;
- дүрмийн сангийнхаа бүтэц, бүрэлдэхүүнд Хорооны зөвшөөрөлгүйгээр оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тайлан, тэнцэлд тусгах;
- нягтлан бодох бүртгэлийг холбогдох журмын дагуу хөтлөхгүй байх, тайлан тэнцлийг зөрүүтэй гаргаж будлиантуулах;
- салбар, төлөөлөгчийн газрыг Хорооны зөвшөөрөлгүйгээр нээн, ажиллуулах;
- байгууллагынхаа дүрмийг зөрчиж Дотоод хяналтын алба, Зээлийн хороогоо зохих журмын дагуу ажиллуулахгүй байх;
- улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэмд орсон өөрчлөлтүүдийг тухай бүр бүртгүүлэхгүй байх зэрэг зөрчлүүд нийтлэг ажиглагдаж байлаа.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбогдуулан нийт 6.03 сая төгрөгийн захиргааны шийтгэвэр ногдуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах үүднээс хугацаатай үүрэг даалгаврыг Улсын байцаагчийн албан шаардлага, тайлангаар өгч, хэрэгжилтийн байдалд нь хяналт тавихын зэрэгцээ тухай бүр зөвлөгөө өгч ажилласны үр дүнд зөрчил, дутагдал багасах хандлага гарч эхэллээ.

Санхүүгийн тайлан, тэнцлийг нэгтгэн, дүн шинжилгээ хийх нь зайны хяналтын үндсэн арга хэрэгсэл бөгөөд тус салбарын статистик үзүүлэлтүүдийг бүрдүүлж, үйлчилгээний цар хүрээ, хүртээмжийг тогтоон, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тайлант онд ББСБ-дын санхүүгийн тайлан, тэнцлийг улирал бүр хүлээн авч, зохистой харьцааны үзүүлэлтүүдийн шинжилгээ хийн дүгнэж, илэрсэн зөрчлийг арилгуулах, авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар холбогдох үүрэг даалгавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Зайны хяналтыг хэрэгжүүлэх явцад Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлх тусгай зөвшөөрлийн журам”-ыг зөрчсөн 14 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 12 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.


### **Д. Зах зээлийн өнөөгийн байдал**



Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 137 ББСБ-ын 112 нь Улаанбаатар хотод, 25 нь орон нутагт бүртгэлтэй, 14 нь Япон, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, БНХАУ, БНСУ, Итали зэрэг орнуудын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай байна.

Тайлант онд ББСБ-дын салбар, нэгжийн тоо 43, хувь нийлүүлэгчдийн тоо 433, ажиллагсдын тоо 647 гаруйд хүрсэн ба давхардсан тоогоор 72.9 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлжээ.

## 1. Нийт актив




ББСБ-дын нийт актив 66.4 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт активын 2.0 хувь, Монгол Улсын ДНБ-ний 1.5 хувьтай тус тус тэнцэж байна.

2006 онд ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор нийт активынх нь жилийн өсөлт 80 хувьтай байсан бол дүрмийн сангийн шаардлагыг хангаагүй зарим ББСБ-ын үйл ажиллагааг зогсоосноос 2007 онд 4 хувиар буурч 66.4 тэрбум төгрөг болсон. Гэсэн хэдий ч шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой хуулийн этгээдийн тоо огцом нэмэгдэж байна.

ББСБ-ын нийт активт эзлэх зээлийн хэмжээ дунджаар 57.6 хувь, мөнгөн хөрөнгийнх 26.2 хувь, эргэлтийн бус хөрөнгийнх 9.3 хувь байв.

## 2. Зээлийн багцын чанар



2005-2006 онуудад нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 6-гаас 4.3 хувь болж буурсан бол 2007 онд 0.2 хувиар өсч 4.5 хувь болж, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 23 хувь буюу 288 сая төгрөгөөр өслөө.

ББСБ-ууд 1.3 тэрбум төгрөгийн зээлийн болзошгүй эрсдэлийн сан байгуулсан нь чанаргүй зээлийн 81 хувьтай тэнцэж байгаа юм.

### 3.Зээлийн хүүгийн түвшин



Сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн байгууллагуудын хооронд өрсөлдөөн эрчимтэй өрнөж, зээлийн хүү тогтвортой буурч байна. 2007 оны байдлаар ББСБ-дын зээлийн сарын дундаж хүү 2.2 хувь болж, 2000-2001 оны үзүүлэлтээс даруй 2 гаруй дахин буурлаа.


### 4.Өөрийн хөрөнгө, дүрмийн сан



ББСБ-ын нийт өөрийн хөрөнгө 48.1 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын эзэмшигчдийн өмчийн 12.8 хувьтай тэнцэж байна.

2006 онд ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор өөрийн хөрөнгийн хэмжээ нь .... хувиар өссөн бол 2007 онд Хорооны шийдвэрээр 36 ББСБ-ын үйл ажиллагааг зогсоосныг үл харгалзан өмнөх оныхтой харьцуулахад 0.84 хувиар нэмэгдэж, дүрмийн сангийн хэмжээ нь 4.14 хувиар буурсан болно. ББСБ-ын өөрийн хөрөнгийн 86.7 хувь нь дүрмийн сангаас бүрдэж байна.

### 5.Бусдаас татсан эх үүсвэр



Зөвхөн банкнаас авсан зээлээр үйл ажиллагаагаа санхүүжүүлж байсан ББСБ-ууд 2004 оноос эхлэн итгэлцэл, мөнгөн гуйвуулга зэрэг шинэ нэр төрлийн үйлчилгээ үзүүлэх, олон улсын санхүүгийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй төслийн бөөний зээлийн үйлчилгээнд хамрагдах замаар эх үүсвэрээ нэмэгдүүлэх болсон.

2007 онд ББСБ-дын нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 41 хувь буюу 7.8 тэрбум төгрөгөөр буурсан нь дунджаар 0.5-2.0 хувийн хүүтэй банкны зээлийн эх үүсвэрийг төлж барагдуулсантай холбоотой юм.

ББСБ-дын итгэлцлээр дамжуулан татаж буй их хэмжээний эх үүсвэр нь хадгаламжийн үйлчилгээнээс төдийлөн ялгарахгүй байгаа нь санхүүгийн салбарын тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүйг анхааран эрх зүйн зохицуулалтыг нь бий болгох шаардлагатай байна.

## 6.Ашигт ажиллагаа



ББСБ-ын ашигт ажиллагааг илэрхийлсэн активын өгөөж (ROA) системийн дунджаар 4.6 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ 6.1 хувьтай байгааг банкны салбарын холбогдох үзүүлэлтүүдтэй харьцуулахад активын өгөөж нь бараг 2 дахин өндөр, өөрийн хөрөнгийн өгөөж нь харьцангуй доогуур байна. Өөрийн хөрөнгийн өгөөж ийнхүү бага байгаа нь нэг талаар ББСБ-ууд санхүүгийн хөшүүргийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа, нөгөө талаар эх үүсвэр болон үйл ажиллагааны бусад зардал нь харьцангуй өндөр байгаагаас шалтгаалж байна.

Сүүлийн жилүүдэд ББСБ-дын зээлийн үйл ажиллагаа өргөжсөнтэй уялдан хүүгийн орлого нь тогтвортойгоор нэмэгдсэн ба зөвхөн 2007 онд 52 хувь буюу 4.7 тэрбум төгрөгөөр өсч 13.8 тэрбум төгрөг боллоо. Харин нийт зардал нь өмнөх оноос 42 хувиар нэмэгдэж 11.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

### **Е.Цаашид авч хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээнүүд**

ББСБ нь санхүүгийн салбарын нэг гол бүрэлдэхүүн хэсэг хэдий ч эрхзүйн орчин, үйл ажиллагааны хувьд төлөвшин бэхжээгүй, ажиллагсдын санхүүгийн удирдлагын мэдлэг дутмаг, хөрөнгийн хэмжээ багаас үйлчлүүлэгчдийн хүрээ цомхон, зах зээлийн хувиарлалтын төлөө өрсөлдөөн өрнүүлэх эрмэлзэлгүй хэвээр байна. Иймд энэ салбарт нэн тэргүүнд авч хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээнүүдийг тоймлон илэрхийлбэл:

-салбарын чиглэлээр гадаад орнуудын хуримтлуулсан туршлагаас судлан шинжилж, бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх дунд хугацааны чиг хандлагыг тодорхойлох;

-салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох хуулиудад санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих чиглэлээр өөрчлөлт оруулж, ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдлөг болгох заавар, журмыг боловсруулан мөрдүүлэх;

-хяналт шалгалтыг тогтмолжуулж, зайны хяналтыг чанаржуулан, нягтлан бодох бүртгэл, тайлагналын тогтолцоог сайжруулах замаар эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлэх;

-ББСБ-дыг нэгдэн томорч, өөрийн хөрөнгийн хэмжээ, санхүүгийн чадавхиа нэмэгдүүлэх ажиллагааг дэмжиснээр үйлчилгээнийх нь чанар, цар хүрээг өргөтгөх;

-ББСБ-дад компанийн засаглалын тохиромжтой хэлбэрүүдийг боловсронгуй болгох;

-Засгийн газар хоорондын болон олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлэх төслийн хүрээнд ББСБ-дад олгох бөөний зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

-салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг болно.

#### **4.ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООД**

Хадгаламж, зээлийн зарим хоршоодын үйл ажиллагаатай холбоотойгоор нийгэмд үүссэн хямралт байдлыг гэтлэн давж, энэ салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгон, зохицуулалт, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн чангатгаж, бүртгэл, тусгай зөвшөөрөл олголтод тавих шаардлагыг өндөрсгөн цэгцэлснээр иргэдээс итгэх итгэлийг сэргээхэд 2007 оны гол зорилт чиглэж байлаа.

#### **А.Иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах талаар**

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа нь санхүүгийн үйл ажиллагаа болохын хувьд “Хоршооны тухай хууль”-иар бус “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” бие даасан хуулиар зохицуулагдах нь зүйтэй гэж үзээд уг хуулийн төслийг хариуцаж боловсруулсан болно. Хуулийн төсөл УИХ-д өргөн баригдсан байгаа ба энэ төсөл хэрхэн батлагдахаас шалтгаалан хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааны цаашдын хөгжлийн чиг хандлага илүү тодорхой болох юм.

ХЗХ-дын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлэх, санхүүгийн чадавхийг нь дээшлүүлэх үүднээс “Хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”, “ХЗХ-ны санхүү төлбөрийн чадвар, газар дээрх хяналт шалгалтын журам” зэрэг журмуудыг шинэчлэн мөрдөх боллоо.

Тайлант онд тусгай зөвшөөрөл авах хүсэлт Хороонд ирүүлсэн 129 хоршооны материалыг хянан шалгаж олгосон бөгөөд Хорооноос тавьж буй нөхцөл, шаардлагыг хангаагүй гэж үзсэн 1 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүллээ.

Зах зээлийн зохицуулалтын хүрээнд хоршоодын хадгаламжийн хүүг банк болон банк бус санхүүгийн байгууллагын дундаж хүүгийн түвшинд ойртуулж, хадгаламжийн хүүгийн зардлыг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангахад голлон анхаарч байна.

УИХ-аас 2007 оны 6 дугаар сард баталсан “Хоршооны тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд энэ оны 10 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах өргөдөл,

материалаа Хороонд ирүүлээгүй 468 хоршоо (Улаанбаатарт – 309, орон нутагт – 159)-г татан буулгах бэлтгэл ажлыг хангаад байна.

### **Б.Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар**

Иргэд маань санхүүгийн байгууллагад хамтын хяналтыг хэрэгжүүлэх зарчим, арга замуудын талаар дулимаг мэдлэг, мэдээлэлтэй байснаас Хадгаламж, зээлийн зарим хоршоодтой холбоотой нийгмийг донсолгосон үйл явдлууд гарсан гэж ойлгон энэ төрлийн мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх талаар анхаарч ажиллав.

Хорооноос ХЗХ-дын талаар авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, хяналт шалгалтын ажлын үр дүн, тусгай зөвшөөрөл олголттой холбоотой мэдээллүүдийг “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”, “Өглөөний сонин”, “С-1”, МҮТВ, SBN зэрэг хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийг өргөн ашиглаж, тухай бүр шуурхай түгээж байлаа.

Хорооноос зохион байгуулсан “Хөрөнгийн зах зээлийн хөгжил” сэдэвт өдөрлөгийн үеэр ХЗХ-дын үйл ажиллагааг зохицуулж буй үйл ажиллагаа, хоршооны тухай хууль тогтоомж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах талаар гарын авлага, унших материал хэвлүүлэн тарааж сурталчлав.

Санхүүгийн зах зээл дээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн байгууллага болох ХЗХ-дын удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх явдал бол салбарын төлөвшилтөд чухал байр суурийг эзлэнэ гэж үзэн дараах сургалт, семинаруудыг бусад байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Азийн болон Монголын ХЗХ-дын холбоодтой хамтран зохион байгуулсан “Хадгаламж зээлийн хоршооны удирдлагын арга хэрэгслүүд” сэдэвт 3 өдрийн сургалт нь СЗХ-ны ажилтнууд, ХЗХ-дын удирдлагад дэлхийн бусад орнуудад ХЗХ-дын хөгжсөн түүх, хүрсэн түвшин, цаашдын хандлага, сургамж, тулгарч буй бэрхшээлүүдийн талаар өргөн ойлголт өгсөн, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэхэд түлхэц болсон үйл явдал болсон юм.

“ХАС” банктай хамтран Завхан, Архангай, Дундговь, Орхон, Дорноговь аймгуудад уг банктай франчайзийн гэрээтэй ажилладаг ХЗХ-дын ажилтнуудад зориулсан сургалтуудыг “Зээлийн эрсдлийн шинжилгээ”, “ХЗХ-дын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин” зэрэг сэдвээр зохион байгуулж, нийт 180 гаруй хүнийг хамрууллаа. Сургалтын явцад оролцогчид ХЗХ-ны мөн чанар, үйл ажиллагааны онцлог, дотоод ардчилалын тухай, хоршооны гишүүдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах, санхүүгийн чадвар, сахилгыг хэрхэн дээшлүүлэх талаар дориун мэдээлэл авч, тодорхой ойлголттой болсон гэж дүгнэж байна.

Сургалт, семинаруудын зэрэгцээ Хорооноос ХЗХ-дын үйл ажиллагааг шалгах явцад тэдгээрийн удирдлага, гишүүдэд дотоод хяналтын механизмыг бүрдүүлэн хэрэгжүүлэх арга замууд, эрх үүргийн хуваарилалт, мэдээ тайлан гаргалтын талаар харамгүй зөвлөгөө өгч ажилласан нь зохих үр дүнгээ өгсөн болно.

Тайлант онд Хадгаламж, зээлийн хоршоодын газрын мэргэжилтнүүд давхардсан тоогоор нийтдээ 336 хуулийн этгээд, 600 гаруй иргэнд хууль эрх зүйн болон мэргэжлийн зөвлөгөө өгсөн байна.

## **В.Санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар**

ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг тууштай хамгаалах, гэмт хэргийн шинжтэй, хууль бус үйлдлүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран таслан зогсоох явдал нь иргэдээс энэ зах зээлд итгэх алдагдсан итгэлийг сэргээн бататгахад чухал үүрэгтэй тул энэ чиглэлээр үзүүлэх төрийн үйлчилгээг ямар нэгэн хүнд сурталгүйгээр, аль болох шуурхай үзүүлэхэд анхаарч ажиллалаа.

Хадгаламж эзэмшигч иргэдээс ХЗХ-нд хадгалуулсан мөнгийг гэрээнд заасан хугацаандаа буцаан олгохгүй байгаа, хүүнд тооцох мөнгийг бүрэн олгохгүй байгаа талаар зонхилон ирүүлсэн 187 өргөдөл, гомдлыг шалган шийдвэрлэж, 26 хүний өргөдөлд дурдсан асуудлууд гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн УМБГ-т шилжүүлэн шалгуулах арга хэмжээ авлаа.

Санхүүгийн хүндрэлд орж, гишүүдийнхээ эрх ашгийг хохироож байсан 6 хоршооны үйл ажиллагаанд Хорооноос тогтмол хяналт тавьж, удирдлагатай нь удаа дараа уулзан шат дараалсан үүрэг, даалгавар өгөх замаар харилцагчдын хохирлыг барагдуулах арга хэмжээ авсан.

ХЗХ-дын үйл ажиллагаанд шалгалт хийх, тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл, материалыг хянах явцад тэдгээрээс хадгаламж эзэмшигчид, гишүүддээ өгвөл зохих мэдээлэл, санхүүгийн тайлан зэргийн хүргэлтийн байдлыг давхар шалган нягталж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар шаардлага тавьж ажилласны дүнд ХЗХ-д хууль тогтоомж, бусад мэдээлэл байршуулдаг сурталчилгааны самбар ажиллуулах, хоршооны танилцуулгыг хэвлэн нийтэлж тараах, Хорооноос хийсэн шалгалтын дүнг гишүүддээ танилцуулах зэрэг ажлуудыг хэвшил болгоод байна.

## **Г.Санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах талаар**

Хадгаламж зээлийн хоршоодын удирдлага хуулийн дагуу үйл ажиллагаагаа хөтлөн явуулах, хадгаламж эзэмшигчид нь дотоод хяналтаа чангатгахыг эрмэлзэх хандлага ажиглагдах болсон нь үр дагавар нь хараахан арилагүй байгаа ХЗХ-дын хямралт байдал энэ төрлийн үйлчилгээнд хамрагдагч талуудад нэгийг ойлгуулсныг харуулж байна. Гэсэн хэдий ч Хороо хяналт шалгалтынхаа ажлыг чангатган тогтмолжуулах, тусгай зөвшөөрлийнхөө нөхцөл шаардлагыг бүрэн хангуулах арга хэмжээнүүдийг авлаа.

Тайлант онд Хороо хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хийх нэгдсэн шалгалтыг “2007 онд санхүүгийн зах зээлд оролцогчид, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хийх шалгалтын нэгдсэн хуваарь”-ийн дагуу 8 удаа зохион байгуулж, 64 хоршоог хамруулж, иргэдийн өргөдөл гомдол, санхүүгийн тайлан мэдээ зэргийг үндэслэн шалгалтын хуваарьт ороогүй 15 хоршоог шалгалаа.

Дараах зөрчил, дутагдлууд нийтлэг байгааг шалгалтын дүн харуулж байна. Үүнд:

-хоршооны засаглал тогтоогүйгээс Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөл, Зээлийн хороог хуулийн дагуу сонгож байгуулдаггүй, Гүйцэтгэх захирлыг томилон гэрээ байгуулан ажиллуулдаггүй;

-дотоод хяналтын механизм бүрдээгүй буюу хангалтгүй ажилладгаас бүх гишүүдийн хурлыг хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулдаггүй, гишүүдэд үйл ажиллагааныхаа талаар үнэн бодит мэдээлэл хүргэдэггүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг зохих журмын дагуу хөтөлдөггүй, хадгаламж, зээлийн хувийн хэргийн бүрдэлт хангалтгүй, хоршооны гишүүн бус этгээдээс хадгаламж авсан, гишүүн бус этгээдэд зээл олгосон, зээл төлөлтийн байдалд тавих хяналт хангалтгүй;

-төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэгч байгууллагатай харилцах соёл, уламжлал дутагдсанаас Хороонд ирүүлбэл зохих тайлан мэдээг ирүүлэхгүй байх, буруу гаргах, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллахгүй байх зэрэг болно.

Шалгалтын дүнг үндэслэн хууль тогтоомж зөрчсөн 5 хоршоонд 460000 төгрөгийн торгууль ногдуулж, 24 хоршоонд улсын байцаагчийн “албан шаардлага”-аар зөрчил арилгах тодорхой үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь тогтмол хяналт тавьж ажиллахын зэрэгцээ харилцагчдынхаа эрх ашгийг хохироож, хадгалуулсан мөнгийг нь гэрээнд заасан хугацаанд өгдөггүй 5 хоршооны удирдлага, үүсгэн байгуулагчдын үйлдлийг гэмт хэргийн шинжтэй гэж үзэн УМБГ-ын ЭЗГХШ хэлтсээр шалгуулахаар шилжүүллээ.


ХЗХ-дын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн тайлан мэдээг улирал тутам хүлээн авч нэгтгэн, цаашид үүсч болзошгүй эрсдэлийн судалгаа хийн тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх талаар тухай бүр зөвлөгөө өгч ажиллаж байна.

#### **Д.Зах зээлийн өнөөгийн байдал**

2007 оны жилийн эцсийн байдлаар Хорооноос хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваад ажиллаж байгаа ХЗХ-дын 100 нь Улаанбаатар хотод, 81 нь орон нутагт бүртгэлтэй байна. Нийт хоршоодын 21 хувь буюу 38 нь Хасбанкны франчайзын үйлчилгээг авч, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хоршоод юм.

### **1. Татсан хадгаламж, олгосон зээл**





ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 2007 оны эцэст 25.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өссөн бол олгосон зээлийн өрийн үлдэгдэл 19.3 тэрбум төгрөг байж, өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар нэмэгдсэн байна.


Татан төвлөрүүлсэн хадгаламжийн 74.5 хувийг зээлийн үйлчилгээнд зориулж, 25.5 хувийг бэлэн болон бэлэн бусаар байршуулсан байна.

## 2. Хоршоодын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



ХЗХ-ны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар /түргэн борлогдох активыг нийт гишүүдээс татсан хадгаламж, бусдаас авсан богино хугацаатай зээлийн эх үүсвэрийн нийлбэрт харьцуулсан үзүүлэлт/-ын эрсдэлгүй байх түвшин 15 хувиас дээш байвал зохистой гэж үздэг. Тэгвэл энэ үзүүлэлт зохистой түвшнээс 33.1 хувиар өндөр байгаа нь системийн хэмжээгээр бусдад төлөх төлбөрийн нэхэмжлэлийг анхны шаардлагаар гүйцэтгэх чадамж сайжирч байгааг харуулж байна.

### 3.ХЗХ-дын активын бүтэц



ХЗХ-дын нийт актив 35 тэрбум төгрөгт хүрч өмөнөх оны мөн үетэй харьцуулахад 44,5 хувиар өссөн байна. 2007 оны жилийн эцсийн байдлаар нийт активын 38,8 хувийг мөнгөн хөрөнгө, 51,4 хувийг зээл, 5,4 хувийг авлага буюу бусад авлага, 0,7 хувийг өмчлөх бусад хөрөнгө, 3,7 хувийг үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Орлого авчирдаг актив хөрөнгийн дүн 61.2 хувиар өсч 18.0 тэрбум төгрөг болж, нийт активын 85 хувьд хүрсэн нь ашигтай ажиллах хандлагатай байгааг харуулж байна. Тайлант онд ХЗХ-д 1.85 тэрбум төгрөгийн хуримталсан алдагдалтай, 1.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласнаас үзэхэд системийн хэмжээнд 50 гаруй сая төгрөгийн цэвэр ашиг гарчээ.


### 4.Хоршоодын зээлийн багцын чанар



ХЗХ-д нийт 19.3 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх оныхоос 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 1.3 хувиар өсч 2.1 тэрбум

төгрөгт хүрчээ. Нийт зээлийн багцад 1.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

### 5.ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгөтэй харьцаа



ХЗХ-дын татан төвлөрүүлсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа 2006 оны эцэст 18.4 хувьтай байсан бол тайлант онд 25 хувь боллоо. Энэ нь хоршоодод санхүүгийн эх үүсвэрээ гишүүдээс хадгаламж татах замаар өсгөх сонирхол давамгайлж байгаа, тэр утгаараа санхүүгийн эрсдэлд өртөх магадлал нь өндөр хэвээр байгааг харуулж байгаа юм.

Гишүүдээс хоршоонд хадгалуулсан мөнгөн хадгаламжийн нийт дүн нь нийт активын 70 хүртэлх хувь байвал зохистой гэж үздэг бөгөөд энэ үзүүлэлт 74 хувьтай байна.

#### **Е.Цаашид авч хэрэгжүүлбэл зохих бодлогын арга хэмжээнүүд**

Санхүүгийн салбарт бичил санхүүгийн байгууллагуудын оруулах хувь нэмэр нэмэгдэж, хэрэглээний зориулалт бүхий бичил зээлийн хүртээмж, цар хүрээ өргөссөөр байгааг харгалзан ХЗХ-ны хөгжлийн чиг хандлагыг нь оновчтой тогтоон, түүнд нийцсэн эрхзүйн орчныг бий болгох шаардлага өнөөгийн тулгамдсан зорилт болж байна.

Юуны өмнө, дараах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэх хэрэгтэй гэж үзэж байгаа болно. Үүнд:

- Салбарын хөгжлийн олон улсын туршлагыг судалж, монгол хөрсөн дээр торнин цэцэглэж чадахуйц загварыг бий болгон нэвтрүүлэх;
- ХЗХ-дыг хамарсан мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эхлүүлэх;
- ХЗХ-дыг олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас олгодог бөөний зээлийн үйлчилгээнд өргөнөөр хамруулах;
- Хөдөө, орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тэнд үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дыг бодлогоор дэмжих;
- Даатгалын зах зээлийн үйлчилгээнд ХЗХ-дыг хамруулах боломжийг судлан үзэж, арга замуудыг тодорхойлох;

- ХЗХ-дын нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлж, бүртгэлээр авах мэдээллийн үнэн бодит байдлыг хангах хэрэгслийг тодорхойлон нэвтрүүлэх зэрэг багтаж байна.

## **ГУРАВ.САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

Хорооны санхүүгийн үйл ажиллагаа нь түүний жигд ажиллагааг хангах, материаллаг баазыг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ажлын байрны нөхцлийг сайжруулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах зорилгоор төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахад чиглэгдлээ.

Монгол Улсын Их Хурлаас Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны төсвийн зардлыг 541.4 сая төгрөгөөр баталсны 381.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 160.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тогтоосноос гадна Монгол Улсыг хөгжүүлэх сангаас ажилтнуудын орон сууцны нөхцөл сайжруулахад зориулж 30 сая төгрөг олгохоор болсон.

### **Орлого**

Хороо тайлант онд хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад улсын төсвөөс 357.9 сая төгрөг авч, төсөвт 151.6 сая төгрөг төвлөрүүлснээс гадна үндсэн үйл ажиллагааны орлогоор 438.8 сая төгрөг олсон байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын 96.8 хувийг зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр, 3.2 хувийг бусад орлогоор бүрдүүлсэн байна.

### **Зарлага**

Хорооны 521.4 сая төгрөгөөр батлагдсан төсвийн урсгал зардлын 351.1 сая нь цалин хөлс ба нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд, 170.3 сая нь бараа, үйлчилгээний бусад зардлуудад оногдож байсан. Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуулийн хугацаанд нь гарган Төрийн сангаар баталгаажуулж ажилласнаар нийт урсгал зардлыг батлагдсан төсвөөс 13.9 сая төгрөгөөр хэмнэсэн болно.

Тээвэр шатахуун, гадаад болон дотоод томилолт, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх, мэдээлэл сурталчилгаа, төлбөр хураамж зэрэг зардлууд 0.4-4.4 сая төгрөгөөр хэмнэгдсэнийг Төрийн сангийн зөвшөөрсний дагуу хэтэрсэн бусад зардлуудыг санхүүжүүлэхэд гүйлгэн шилжүүлсэн болно.

Батлагдсан төсвөөс хэтэрсэн зардлуудыг ангилан үзүүлбэл:

- бичиг хэргийн материалын зардал зохицуулалтын хүрээний салбаруудын бүх хуулийн этгээдийн нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийг хүлээн авч нэгтгэн, зайны хяналтын шинжилгээг хийж гүйцэтгээд хариу мэдээлэхэд гарч байгаа албан бичиг хөтлөлтийн зардал нэмэгдсэнээс шалтгаалан 1.0 сая төгрөгөөр;
- шуудан холбооны зардал Хорооны ажилтнуудын ажлын байрны байршил 2 ч удаа өөрчлөгдсөнтэй холбогдон телефон утаснуудыг шилжүүлэх, нэмж суурилуулах зэрэг нэмэлт зардлууд гарснаас 1.9 сая төгрөгөөр;
- эд хогшил худалдан авах зардал УИХ-ын шийдвэрээр Хорооны ажилтнуудын орон тоо нэмэгдсэнтэй уялдан ажилтнуудын ажлын байрны хангалтад зориулж тавилга,

эд хогшил, техник хэрэгсэл авах, интернетийн тоног төхөөрөмж худалдан авч суурилуулахтай холбоотойгоор 2.6 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Тайлант онд байгууллагын хэмжээгээр өр, авлага үүсгэлгүй ажиллалаа.

### **Өмч хөрөнгө**

Тайлангийн хугацаанд Хорооны өмч хөрөнгийн дүн нийтдээ 162.1 сая төгрөгөөр нэмэгдсэнийг задлан харуулбал:

- Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн хорооны шийдвэрээр Санхүүгийн зохицуулах хорооны өмчид шилжин ирсэн Засгийн газрын IV байрны өргөтгөлийн байранд хийгдсэн 52.6 сая төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтыг буцаан олгож, тайлан балансдаа тусгасан;
- Төрийн өмчийн хорооны шийдвэрээр Хорооны үйл ажиллагааг хөдөө, орон нутагт хүргэх бололцоог нэмэгдүүлэх зорилгоор 56.8 сая төгрөгийн үнэ бүхий “Ланд круйзер-105” маркийн автомашин авсан;
- тоног төхөөрөмж, техник хэрэгсэл 32.1 сая төгрөгөөр, тавилга, аж ахуйн эд хогшил 20.6 сая төгрөгөөр тус тус авсан байна.

Монгол улсыг хөгжүүлэх сангаас хуваарилсан 30.0 сая төгрөгийг “Төрийн албаны тухай” хууль, “Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу Ажлын албаны даргын шийдвэрээр зарим ажилтны орон сууц авахад дэмжлэг үзүүлэх зориулалтаар зарцуулсан болно. /СЗХ-ны 2007 оны санхүүгийн тайлан тэнцлийг хавсаргав./

### **ХОРОО 2008 ОНД:**

- “Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн жил”-ийн ажлын хүрээнд авсан арга хэмжээнүүдийн үр дүнг нэгтгэн үзээд, хэдийгээр төлөвлөсөн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж чадаагүй ч энэ зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлж, өөрчлөлт хийх эхний алхмууд тавигдсан гэж дүгнэн, шинэ он бүрийг байгууллагынхаа стратеги төлөвлөгөөнд тусгагдсан аль нэг зорилтыг хэрэгжүүлэхэд дорвитой ахиц гаргах “нэрэмжит жил” болгон зарлах явдлыг уламжлал болгон үргэлжлүүлэх зорилгоор 2008 оныг “Бичил санхүүгийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлав. Энэ дагуу тодорхой төлөвлөгөөний дагуу, ялангуяа, ББСБ, Даатгал, ХЗХ-дын салбарт тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэн, бичил санхүүгийн салбарын ажилд бодитой өөрчлөлт гаргахаар тооцож байна.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээнд заагдсан ажил, арга хэмжээнүүдийг тогтоосон хугацаанд нь хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдол өгөн, чармайн ажиллана.
- Санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын ёс зүй, хариуцлага, сахилга батад тавих шаардлагыг чангатгахад эрхзүйн болон бусад зохицуулалтын үйл ажиллагааг чиглүүлж, төрийн хяналтын тогтолцооны зайнаас хянах механизмд эрсдэлийн шинжилгээ хийх аргачлал, арга зүйг боловсруулан мөрдлөг болгоно.

- Ажлын албаныхаа бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын байрных нь нягтралыг сайжруулах, мэргэшсэн боловсон хүчнээр бэхжүүлэх, үйл ажиллагаа бүрийг нь стандартжуулах талаар байнгын эрэлхийлэл хийн шийдвэрлэх бөгөөд Хорооны “Санхүүгийн боловсрол сургалт, мэдээллийн нэгдсэн төв”-ийн барилгыг барих ажлыг эхлүүлнэ.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО